



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27¹.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.5, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийг зохицуулах түр журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг ханган, зохион байгуулалтын арга хэмжээ авч, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд /Л.Халтар/, аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Т.Гантулга/, Онцгой байдлын ерөнхий газар /бригадын генерал Г.Ариунбуян/, Цагдаагийн ерөнхий газар /цагдаагийн хурандаа Ж.Болд/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын 2020 оны "Түр журам батлах тухай" 156 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА:



С.АМАРСАЙХАН

ХОТ ХООРОНДЫН ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед аймаг, нийслэл буюу орон нутаг хооронд /цаашид "Хот хооронд" гэх/-ын зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2. Түр журам нь хот хоорондын тээврийн үйлчилгээ эрхлэгч нар түүнд хяналт тавьж буй төрийн байгууллага, аж ахуйн нэгж /авто, төмөр зам болон агаарын тээвэр/, зорчигч иргэдэд хамаарна.
- 1.3. Энэхүү түр журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль, тогтоомж, тогтоол, шийдвэр болон бусад журмаар зохицуулна.

Хоёр. Зорчигч тээврийн зохион байгуулалт

2.1. Коронавируст (Ковид-19) халдварын тохиолдол илэрсэн бүс нутгаас ирсэн зорчигчийн дараах бичиг баримтыг шалган, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж хот хооронд нэвтрүүлнэ.

Үүнд:

- 2.1.1. Иргэний үнэмлэх болон хувийн мэдээллийг нотлох бусад бичиг баримт;
- 2.1.2. Коронавируст (Ковид-19) халдварын "ПГУ"-ын шинжилгээний "Сөрөг" хариу; /72 цагийн дотор гарсан сүүлийн шинжилгээний хариу/;
- 2.2.3 Хамт болон дагалдан яваа гэр бүлийн гишүүдийн аль нэг нь Коронавируст (Ковид-19) халдварын "ПГУ"-ын шинжилгээ өгсөн байж болно.

2.2. Коронавируст (Ковид-19) халдварын эсрэг вакцины бүрэн тун авсан эсхүл тус халдварт өвчнөөр өвчилж, эдгэрсэн иргэдийн мэдээллийг шалгаж, тэдгээрийн хот хооронд зорчих хөдөлгөөнийг бүртгэлжүүлж, нэвтрүүлнэ.

2.3. Албаны болон шуурхай ажлын шугамаар хот хооронд дамжин өнгөрч буй, эсхүл 24 цагийн хугацаанд ирж, буцах зорчигчийг тухайн харьяалах байгууллагын томилголт, холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн нэвтрүүлж, гэрийн ажиглалтад шилжүүлэхгүй.

2.4. Коронавируст (Ковид-19) халдварын тохиолдол илрээгүй бүс нутгаас зорчих хөдөлгөөнөө эхэлсэн зорчигчдоос Коронавируст (КОВИД-19) халдварын "ПГУ"-ын шинжилгээний хариу шаардахгүй бөгөөд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж, эрүүл мэндийн асуумжийг үндэслэн хот хооронд нэвтрүүлнэ.

2.5. Коронавируст (Ковид-19) халдварын тохиолдол илэрсэн бүс нутгаас тээвэрлэлт гүйцэтгэсэн жолоочийн ажил, амралт болон халдвар хамгааллын дэглэмийг сахиулахад тухайн орон нутгийн Онцгой комиссын Шуурхай штаб хяналт тавьж, шинжилгээнд хамруулж буцаана.

Гурав. Тээврийн хэрэгслээр зорчих иргэдэд тавигдах шаардлага, хүлээх үүрэг

3.1. Иргэн Коронавируст (Ковид-19) халдварын тохиолдол илэрсэн бүс нутгаас хот хооронд зорчихдоо "ПГУ"-ын шинжилгээний "серег" хариу, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах бичиг баримтыг биедээ авч явах бөгөөд замын шалган бүртгэх товчоодод тухай бүр шалгуулна.

3.2. Зорчигч тээврийн хэрэгслээр зорчихын өмнө нэг удаагийн амны хаалт, бээлий, гар халдваргүйжүүлэгч, хувийн хэрэгцээний эд зүйлс, замд хэрэглэх хоол, хүнс болон хогийн уутыг урьдчилан бэлтгэсэн байна.

3.3. Зорчигч тээвэрлэлтийн туршид халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж, (хооллохоос бусад нөхцөлд нэг удаагийн амны хаалтыг авахгүй байх 2 цаг тутам эсхүл бохирдсон тухай бүр амны хаалтыг солих, нэг удаагийн бээлийг өмсөх, гараа тогтмол халдваргүйжүүлэх, бусадтай биеэр хүрэлцэхгүй байх, ойролцоо суудалд зорчиж буй бусад хүнтэй харьцах үедээ амны хаалт хэрэглэж, хүн хоорондын зай барих), эрх бүхий ажилтан, албан хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.

3.4. Зорчигч өөрийн бэлтгэсэн хогийн уутанд хог хаягдлаа хийн битүүмжилж хог хаягдлыг цуглуулах цэгт төвлөрүүлнэ.

3.5. Тээврийн хэрэгсэл дотор болон гадагш нус, цэр, шүлс, хог хаягдлыг ил задгай хаяхыг хориглоно.

3.6. Халдварын сэжигтэй шинж тэмдэг илэрвэл өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг эрсдэлд оруулахаас сэргийлж, энэ талаар тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтанд нэн даруй мэдэгдэнэ.

Дөрөв. Тээврийн байгууллагад тавигдах шаардлага

4.1. Хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн тасалбарыг цахимаар худалдаалах нөхцөлийг бүрдүүлж, цахимаар худалдаалах боломжгүй тохиолдолд халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж, үйлчилгээ үзүүлнэ.

4.2 Тээвэрлэгч нь нэг удаагийн амны хаалт, бээлий, гар халдваргүйжүүлэгчийг урьдчилан бэлтгэж, зорчигчдыг худалдан авах нөхцөлөөр хангана.

4.3. Зорчигчийн сүүлийн 72 цагийн хугацаанд гарсан /ПГУ/-ын шинжилгээний "серег" хариуг хянан шалгаж, тээврийн хэрэгсэлд нэвтрүүлнэ.

4.4. Агаарын хөлөг, зорчигчийн вагон, автобусаар зорчих зорчигчдоос хүн хоорондын зай барьж зорчих /1.5 - 2 метр/, амны хаалт зүүх, халдвар хамгааллын дэглэм мөрдөж үйлчлүүлэхийг шаардаж, заавар, зөвлөмжөөр хангана.

4.5 Биеийн халуун 37.1 хэмээс дээш болон коронавируст (Ковид-19) халдварын бусад шинж тэмдэг илэрсэн зорчигчийг тээвэрлэхгүй ба холбогдох эрүүл мэндийн байгууллагад хандахыг зөвлөнө.

4.6. Зорчигчийг тасалбарт бичигдсэн суудалд суух, суудал солихгүй, зайлшгүйгээс бусад тохиолдолд суудлаас босохгүй байх, амны хаалтыг тогтмол зүүх, бусад зорчигчтой харьцахгүй байх зэргийг зорчигчид анхааруулж, хяналт тавина.

4.7. Ажилтан, албан хаагчдыг Коронавируст (Ковид-19) халдварын "ПГУ"-ын шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.

4.8 Тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэхэд шаардлагатай бодисыг байрлуулж, 2 цаг тутамд халдваргүйжүүлнэ.

4.8. Авто тээврийн үйлчилгээний байгууллага дараах шаардлагыг хангана:

4.8.1. Эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр зорчигч тээврийн үйлчилгээний цагийн хуваарьт зохицуулалт хийнэ;

4.8.2. Тээврийн багийн бүрэлдэхүүнд энэхүү түр журам болон онцгой нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлэх заавар, зөвлөмжийг танилцуулж, сургасан байна;

4.8.3. Тээврийн багийг нэг удаагийн амны хаалт, бээлий, анхны тусламж, цэвэрлэгээний цомог, гар халдваргүйжүүлэгч, хогийн уут зэргээр хангана;

4.8.4. Автобусны эхний эгнээг чөлөөлж, ээлжийн жолоочийн амрах хэсгийг гаргах бөгөөд жолооч нарыг тусгаарлах хаалтаар зорчигчдоос тусгаарлана;

4.8.5. Тээврийн хэрэгсэлд хөшигнөөс бусад суудлын бүрээс, гоёлын эд зүйл зэрэг халдварын эрсдэлтэй хэрэгсэл ашиглахгүй байх, гадаргууг халдваргүйжүүлэх бодисыг байрлуулж, зорчигч бүр гадаргуугийн халдваргүйжүүлэлт хийх нөхцөлийг бүрдүүлнэ;

4.8.6. Тээврийн хэрэгсэлд зорчигчийг суулгах зохицуулалт хийж, тэмдэглэгээ хийсэн байна;

4.8.7. Удаан хугацаагаар тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх бол 2 цаг тутам тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийж, зорчигчдод халдвар хамгааллын дэглэмийг сахиулна. Зорчигч солигдох бүрт халдваргүйжүүлэлт хийнэ.

4.8.8. Тээвэрлэгч нь зорчигчийг бүрэн буулгасны дараа тээврийн хэрэгсэлд эцсийн халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг дагуу хийнэ.

4.9. Төмөр замын тээвэрлэгч байгууллага дараах шаардлагыг хангана:

4.9.1. Ажилтнуудад энэхүү түр журам болон бусад холбогдох заавар, чиглэл, халдвар хамгааллын дэглэмийн талаар зааварчилгаа өгч хэрэгжилтэд хяналт тавина;

4.9.2. Ажилтнуудыг нэг удаагийн амны хаалт, бээлий, анхны тусламжийн болон цэвэрлэгээний цомог, гар халдваргүйжүүлэгч, зайнаас халуун хэмжигч, хогийн уут зэргээр хангана;

4.9.3. Зорчигчийн вагонуудад анхны тусламжийн болон цэвэрлэгээний цомог, гар халдваргүйжүүлэгч, зайнаас халуун хэмжигч, хогийн уутыг байрлуулсан байна.

4.9.4. Зорчигчийн вагонд 2 цаг тутамд халдваргүйжүүлэлт хийнэ;

4.9.5. Зорчигчийн вагоны цонхны хөшигнөөс бусад гудас, бүтээлэг, ор хөнжлийн даавуу зэрэг халдварын эрсдэлтэй эд зүйлс ашиглахгүй;

4.9.6. Галт тэргэнд ажилтан болон зорчигч хувийн ариун цэврийг хэрхэн сахих, халдвараас сэргийлэх талаарх зөвлөмжийг байрлуулж, мэдээллээр хангасан байна;

4.9.7. Галт тэрэгний ариун цэврийн өрөөнд гар угаах шингэн саван, цаасан алчуур, гар халдваргүйжүүлэгч болон хог хаягдлыг цуглуулах уутыг хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулна.

4.9.8. Халдварын сэжигтэй тохиолдол илэрвэл галт тэрэгний дарга нь диспетчерээр дамжуулан тухайн орон нутгийн Онцгой комиссын Шуурхай штабт мэдэгдсэний дагуу бэлэн байдлыг хангуулна;

4.9.9. Галт тэрэгний ажилтан зорчигчийн иргэний үнэмлэх, зорчих тасалбар болон "ПГУ"-ын шинжилгээний "сөрөг" хариуг шалгаж, суулгана;

4.9.10. Галт тэргэнд халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар эсхүл мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хийнэ;

4.9.11. Галт тэргэнд ажил үүрэг гүйцэтгэх ажилтнуудыг коронавируст (Ковид-19) халдвар илрүүлэх шинжилгээнд тогтмол хамруулна;

4.9.12. Галт тэргээр зорчиж буй иргэдээс эрүүл мэндийн асуумж авч, холбогдох мэргэжлийн байгууллагад мэдээлэл хүргүүлнэ;

4.9.13. Тээвэрлэлтийн үргэлжлэх хугацааны турш зорчигчдод хоол хүнсний зүйлсээр үйлчилгээ үзүүлэхгүй. Зайлшгүй шаардлагаар уух зүйлээр үйлчлэх бол нэг удаагийн хэрэглээний аяга ашиглан тавиур дээр байрлуулан өгнө. Гараас гарт өгөхийг хориглоно. Үйлчилгээ үзүүлсний дараа тавиурыг халдваргүйжүүлнэ.

4.10. Агаарын тээвэрлэгч байгууллага дараах шаардлагыг хангана:

4.10.1. Нислэгийн чиглэл, маршрут, цагийн хуваарийг урьдчилан батлуулж нислэгийн зөвшөөрөл авна;

4.10.2. Нисэх бүрэлдэхүүн, техник үйлчилгээний болон газрын үйлчилгээний ажилтнуудад үйл ажиллагаанд мөрдөх холбогдох заавар журмыг танилцуулж, аймаг, нийслэлийн онцгой комиссын шуурхай штабын утасны дугаарыг бэлтгэж өгнө;

4.10.3. Нисэх бүрэлдэхүүн болон газрын үйлчилгээний ажилтнуудад халдвар хамгааллын иж бүрэн хувцас, нүүрний хаалт, нэг удаагийн амны хаалт, бээлий, гар халдваргүйжүүлэгч, цэвэрлэгээний бодис, хог хийх уут зэргээр хангана;

4.10.4. Нислэгийн турш ариун цэврийн өрөөнд гар угаах шингэн саван, цаасан алчуур, гар халдваргүйжүүлэгч болон хог хаягдлыг цуглуулах уутыг шаардлагатай цэгүүдэд хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулна;

4.10.5. Зорчигчийн суудал бүрд нислэгийн үед баримтлах халдвар хамгааллын дэглэмийн тухай санамж, анхааруулга байрлуулна;

4.10.6. Зорчигчийн амны хаалтыг 2 цаг тутамд, бохирдсон тохиолдолд солиулах ба хэрэглэсэн амны хаалтыг суудлын урд байрлах цаасан уутанд хийж, шар өнгийн хогийн уутанд цуглуулна;

4.10.7. Нислэгийн явцад агаарын хөлгийн дарга, нисгэгч бүхээгийн хаалгыг нээхгүй, шаардлагатай тохиолдолд агаарын хөлгийн үйлчлэгчтэй дотуур холбоогоор холбогдоно;

4.10.8. Нислэгийн үргэлжлэх хугацааны турш зорчигчдод хоол хүнсний зүйлсээр үйлчилгээ үзүүлэхгүй. Зайлшгүй шаардлагаар уух зүйлээр үйлчлэх бол нэг удаагийн хэрэглээний аяга ашиглан тавиур дээр байрлуулан өгнө. Гараас гарт өгөхийг хориглоно. Үйлчилгээ үзүүлсний дараа тавиурыг халдваргүйжүүлнэ;

4.10.9. Халдварын сэжигтэй тохиолдол илэрвэл агаарын хөлгийн дарга нь нисэн очих нисэх буудлын Нислэгийн хөдөлгөөний ажилтнаар дамжуулан тухайн орон нутгийн Онцгой комиссын шуурхай штабт мэдэгдсэний дагуу агаарын хөлгийг нисэх буудалд буухаас өмнө бэлэн байдлыг хангуулна;

4.10.10. Агаарын хөлгийн зорчигчийн бүхээгийн хүрэлцэх гадаргуу, ариун цэврийн өрөөнд нислэг үйлдэхээс өмнө болон нислэгийн дараа халдваргүйжүүлэлт хийж, хог хаягдлыг цуглуулан амыг сайтар битүүмжилж, зориулалтын цэгт төвлөрүүлнэ.

4.11. Авто болон төмөр зам, нисэх буудлууд дараах шаардлагыг хангана:

4.11.1. Ирэх, явах зорчигч, орох гарах хөдөлгөөнийг нэг чиглэлийн урсгалаар давхцуулахгүй байхаар зохион байгуулна;

4.11.2. Бүртгэлийн цэг, хүлээлгийн танхимд зорчигч, иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүй, хүн хоорондын зайг бариулж, тэмдэг тэмдэглэгээг байршуулсан байна;

4.11.3. Үйлчилгээний ажилтнуудыг нэг удаагийн амны хаалт, /нүүрний хамгаалах халхавч/ бээлий хэрэглэж иргэдэд үйлчилж хэвшүүлэх, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулна;

4.11.4. Халдварын сэжигтэй зорчигч илэрсэн үед холбогдох байгууллагад мэдэгдэж эрүүл мэндийн шуурхай хариу арга хэмжээний багт шилжүүлэх хүртэл бусад зорчигчоос түр тусгаарлаж, ойрын хавьтлыг тогтоосон байна;

4.11.5. Зорчигч, тэдгээрийн гар тээш, тээш болон ачаанд халдваргүйжүүлэлт хийнэ;

4.11.6. Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах чиглэлээр мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, ухуулах хуудас зэргийг бэлтгэн нийтийн эзэмшлийн талбай, нийтийн тээвэр, олон нийтийн үйлчилгээний газраар зорчих иргэдэд түгээж, байрлуулан, зарлан мэдээллийн давтамжийг нэмэгдүүлнэ;

4.11.7. Захиргаа, үйлчилгээний ажилтнуудад үйл ажиллагаанд мөрдөх холбогдох заавар журмыг танилцуулж, аймаг, нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын утасны дугаарыг бэлтгэж өгсөн байна;

4.11.8. Үйлчилгээний заал танхимуудад мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу халдваргүйжүүлэлт хийнэ;

4.11.9. Хог хаягдлаа төрөлжүүлж, зориулалтын саванд цуглуулан, тухай бүр зайлуулна.

Тав. Хувийн болон албаны тээврийн хэрэгслээр зорчих иргэдэд тавигдах шаардлага, хүлээх үүрэг

5.1. Хувийн /Автомашин, мотоцикл, ердийн хөсөг, унадаг дугуй бусад хөдлөх хэрэгсэл/ болон албаны тээврийн хэрэгслээр зорчих жолооч, зорчигч нь хот хооронд зорчихдоо "ПГУ"-ын шинжилгээний "сөрөг" хариу, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг, албан ажлаар зорчих бол албаны үнэмлэх, томилолт эсхүл тодорхойлолтыг биедээ авч явна.

5.2. Зорчих явцад хэрэглэсэн амны хаалт, бээлий, ахуйн хог хаягдлыг тухайн тээврийн хэрэгслийн жолооч цуглуулж, хог хаягдлыг цуглуулах цэгт битүүмжлэн хаяна.

5.3. Коронавируст (Ковид-19) халдварын эсрэг вакцины бүрэн тун авсан эсхүл тус өвчнөөр өвдөж, эдгэрсэн бол энэ талаарх баримтыг авч явна.

5.4. Коронавируст (Ковид-19) халдварын тохиолдол илэрсэн бүс, нутгаас өөрийн оршин суух газар руу зорчиж буй эсхүл удаан хугацаагаар байрлах иргэн 7 хоногийн хугацаанд гэрийн тусгаарлан ажиглалтад байна.

5.5. Коронавируст (Ковид-19) халдварын тохиолдол илрээгүй бүс, нутгаас зорчиж буй иргэн эрүүл мэндийн асуумжийг үнэн зөв бөглөж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөнө.

Зургаа. Аймаг, нийслэлийн Онцгой комиссын үүрэг

- 6.1. Онцгой комиссын Шуурхай штабаас зорчигч тээвэрлэлтийн хөдөлгөөний мэдээллийг нэгтгэн боловсруулж, Улсын Онцгой комиссыг мэдээллээр хангах.
- 6.2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг зохицуулахтай холбоотой хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний журам, заавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавина.
- 6.3. Коронавируст (Ковид-19) халдварын шинж тэмдэг бүхий зорчигчийн талаарх мэдээлэл ирвэл холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу хариу арга хэмжээг нэн даруй авна.
- 6.4. Коронавируст (Ковид-19) халдварын тохиолдол илэрсэн бүс, нутгаас өөрийн оршин суух газар руу зорчиж буй эсхүл удаан хугацаагаар байрлах иргэдийн гэрийн тусгаарлан ажиглалтад хяналт тавих ажлыг зохион байгуулна.
- 6.5. Коронавируст (Ковид-19) халдварын тохиолдол илэрсэн бүс нутгаас тээвэрлэлт гүйцэтгэсэн авто тээврийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын жолоочийн ажил амралт болон халдвар хамгааллын дэглэмийг сахиулан, хяналт тавьж буцаана.

Долоо. Бусад

- 7.1. Түр журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан тогтоол, шийдвэр, заавар, дүрэм, журамд нийцсэн байна.
- 7.2 Энэхүү түр журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд "Зөрчлийн тухай хууль", "Гамшгаас хамгаалах тухай" хууль, "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

— ооо —